



mozaLearn

Mozaik Education

Боловсролын
шинэлэг
шийдлүүд

mozaWeb.com

Mozaik Education

Somogyi utca 19, 6720 Szeged, Hungary • Phone: +36 62 554 664
E-mail: office@mozaweb.com • Web: www.mozaweb.com

MOZAIK



Mozaik Education

- *Mozaik Education нь 1990 онд сурах бичгийн хэвлэлийн газрын үйл ажиллагаа эрхэлж эхэлсэн. Одоо бид хамгийн том дижитал агуулга нийлүүлэгчдийн нэг болж чадсан.*
- *Тус компанийг багш нар, программ хангамжийн инженерүүд үүсгэн байгуулсан бөгөөд энэ нь боловсрол, программ хангамж хөгжүүлэлтийн өвөрмөц хослолыг бий болгосон.*
- *200 ажилтантайгаар 100 гаруй цахим боловсролын төсөл хэрэгжүүлж байна.*
- *3D үзэгдэл, сургалтын видео, цахим хичээл, мөн түншүүдийнхээ хүсэлтээр гэх мэт интерактив агуулгын тасралтгүй хөгжүүлэлт хийдэг.*
- *Хамгийн сүүлийн үеийн төхөөрөмжүүдээр тоноглогдсон мэргэжлийн хэвлэлийн газар.*
- *Олон улсын агуулга хөгжүүлэлт: манай агуулгыг 40 гаруй хэл дээр ашиглах боломжтой.*



Манай дэлхий даяарх түншүүд





MOZAİK

mozaLearn боловсролын цогц систем

mozaLearn нь багш нарын ажлыг хөнгөвчлөх зорилгоор, ажлын шаардлагын дагуу тусгайлан хийсэн мэргэжлийн цахим боловсролын систем юм. Боловсролын системийг бүхэлд нь хамарсан (1-12 дугаар анги, бүх хичээл), бөгөөд сурагчид, эцэг эхчүүдэд тодорхой дэмжлэг үзүүлдэг.

3+1 хамгийн гол багц нь юм.

- **mozaBook** интерактив сургалтын үзүүлэнгийн программ
- **mozaWeb** гэртээ бие даан суралцахад дэмжлэг болох онлайн платформ
- **mozaLog** сурагчид болон сургуулийн бүртгэл мэдээллийн систем
- **медиа сан** интерактив агуулгын цуглуулга.





Цахим шийдлүүд

- интерактив самбарт
- гэртээ цахимаар бие даан суралцахад
- сургуулийн бүртгэл мэдээлэлд зориулсан цахим шийдэлүүд

mozaBook

интерактив самбарт зориулсан цахим сурах бичгүүд

mozaBook нь интерактив самбарт зориулсан үзүүлэнгийн программ юм. Цахим сурах бичгүүд нь бичвэр болон зурагтай хэвлэлийн эхийг интерактив байдлаар ашиглах боломжтой 3D үзэгдэл, видео, дасгал, сэдэвчилсэн хэрэгслүүдээр баяжуулж илүү сонирхолтой болгодог.




MOZAIK

6

Үзэмжтэй дасгалын дэвтрүүдийг хэдхэн товшилтоор

Дэвтрийн хуудаснуудын арын дэвгэрийг загвараар нь ангилсан олон төрлийн зургаар чимэглэж болно. Дэвсгэр зураг болон шугам нь бэхлэгдсэн байдаг тул засвар хийх, болон үзүүлэнг толилуулах явцад саад болохгүй.



Дасгалын дэвтэрт бичиж, зурж, үзэмжтэй хөдөлгөөнт үзүүлэн бэлтгэх боломжтой. Үзүүлэндээ бичвэр, зураг, видео болон 3D үзэгдлүүдийг ашиглаж болно.



Зургийн сан

mozaBook-ийн зургийн санд хичээл болон сэдвээр нь ангилсан, манай график дизайнеруудын зурсан, хэмжээг нь дураараа өөрчилж болох зураг, дүрслэлүүд байдаг ба дасгалын дэвтрээ чимэглэхэд ашиглах боломжтой.




Media сан – Ертөнцийг харах цонх

mozaBook-ийн медиа сан нь интерактив сургалтын материалын дуусахгүй эх сурвалж юм. Та тэндээс манай хэдэн мянган интерактив нэмэлт агуулгуудыг сэдвээр нь ангилан хайж, мөн зураг, видео, аудио интернэтээс ч олох боломжтой.



Визуал зургийн хэрэгсэл


Визуал зургийн хэрэгслийн хэрэглэгчийн интерфэйс нь интерактив самбар дээр хамгийн бяцхан сурагчдад ч зураг зурах үйлдлийг хялбархан тоглоом болгон хувиргадаг. Төрөл бүрийн үзгийн савнууд нь сонгосон үзүүлэнгийн горимд тохирсон харандааны багцуудыг агуулдаг.



Дасгал засварлагч

mozaBook-ийн дасгал засварлагч хэрэгслээр тодорхой зорилгоор, үзэмжтэй дасгалын хуудсуудыг хялбархан бэлтгэх боломжтой ба сурах бичиг, дасгал ажлын дэвтэрт байрлуулан, хичээл дээр ажиллуулж болно.

Та дасгалын олон төрлөөс сонгож (энгийн сонголттой, хосыг нь олох, үгийн сүлжээ, алдааг олох, дараалуулах, газрын зураг дээр байрлуулах, хүснэгт бөглөх гэх мэт), зураг, дүрслэл, видео, аудио медиа сан болон интернэт (жишээлбэл YouTube видео), өөрийн компьютероос оруулах боломжтой.




Үүсгэсэн дасгалын хуудсуудыг сургууль, үндэсний түвшинд ч хуваалцах боломжтой бөгөөд багш нар тэдгээр дасгал ажлын хуудсыг бүтнээр нь болон хэсэгчлэн хичээлдээ хэрэглэх боломжтой.



Онлайнаар ашиглах боломжтой интерактив сурах бичгүүд нь бие даан суралцах, мэдлэг, чадвар сайжруулахад чиглэдэг.




3D үзэгдэл, дасгал болон бусад нэмэлт материалууд нь сурагчдад үзсэн сэдвээ гүнзгийрүүлэн судлахад тусалдаг. tozaWeb-ийг ямар ч нэмэлт программ суулгахгүйгээр, дурын интернет хөтчөөр хэрэглэх боломжтой.




Хэрэгслүүд

Хичээлийн нэрээр ангилсан 120 гаруй tozaTools хэрэгсэлийг сурагчид, багш нар хэрэглэх боломжтой. Хэрэгслүүдийн тоо, функц нь байнга нэмэгдэж байдаг ба хөгжилтэй тоглоом хэлбэрээр суралцах, сурсан зүйлээ бататгах, гүнзгийрүүлэх боломжийг олгодог.



Медиа сан

tozaWeb-ийн медиа санд сурах бичиг дэхь интерактив агуулгууд ангилсан, хайлт хийх боломжтой хэлбэрээр байдаг. Сургалтын материалтай холбогдох видео, аудио, зураг, 3D үзэгдэл, дасгал болон нэр томъёоны тайлбарыг цагаан толгойн үсгийн дарааллаар нээлттэй байгаа сурах бичгээс, бүх сурах бичгээс сонгосон сэдвийн дагуу, эсвэл медиа сангаас бүхэлд нь харуулах боломжтой байдаг.



Дадлагалжуулах болон чадвар хөгжүүлэх тоглоомууд

tozaWeb-ийн байнга өргөжих логикийн, давтах болон ур чадвар хөгжүүлэх тоглоомууд нь зөвхөн тоглохын зэрэгцээ үзсэн хичээлээ давтах, гүнзгийрүүлэхэд тусладаг. Онлайн тоглоомуудын тусламжтайгаар сурагчид найз нар, ангийнхантайгаа тоглох боломжтой болно.



сэдэвчилсэн хэрэгслүүд

Манай интерактив хэрэгслүүд нь хичээлийг хялбархан ойлгож, олж авсан мэдлэгээ тоглонгоо гүнзгийрүүлэх өргөн боломжийг олгодог.

- Байнга өргөжин нэмэгдэх 120 гаруй сэдэвчилсэн хэрэгсэл.
- Багш, сурагчид онлайнаар хандахад нээлттэй.



Молекулууд



Амьд байгаль




Мининот



Шоо



Метроном



Тоон шулуун



Цаг агаар



Календарь




Үгийн картууд



Диаграм

Ур чадвар хөгжүүлэх

Бага ангийн сурагчдад зориулсан хэрэгслүүд нэн тэргүүнд ур чадвар хөгжүүлэх зорилготой.



Одоогоор 120 гаруй хэрэгсэл ашиглагдаж байгаа бөгөөд шинэ функцүүдээр өргөжин, тоо нь үргэлж нэмэгддэг. Эдгээр хэрэгслүүдэд багш нар тоzaBook программаас, сурагчид www.tozaweb.com вэб хуудсаар хандан ашиглаж болно.

Анимейшнүүд

Зарим хэрэгслүүд нь хөдөлгөөнт дасгалуудтай бөгөөд суралцах явцыг илүү сонирхолтой болгодог.




mozaik3D

интерактив 3D үзэгдлүүд

Сурах бичгүүдийн бичвэр, зураг, дүрслэлийн мэдээллийг бидний өөрсдийн бүтээсэн 1300 гаруй 3D үзэгдлээрүүд баяжуулж болно. Ийнхүү цахим сурах бичгүүдийг баяжууланснаар хичээлийн агуулгыг үр дүнтэйгээр өргөсгөж, хичээлийг илүү гоё, сонирхолтой болгож өгдөг.

Биологи 3D үзэгдэл – Чих болон чихний сонсголын явц





- Томруулж, эргүүлэх боломжтой загварууд.
- Хэрэглэхэд хялбар, нэгдмэл интерфэйс.
- Ихэнх үзүүлэн нь анимэшний тусламжтайгаар тойрон алхах боломжтой, хүүрнэл тайлбартай, нэмэлт дасгалуудтай байдаг.



Түүх 3D үзэгдэл – Акрополис (Афин)

Түүх амилна
Эрт үеийн устаж үгүй болсон барилгууд дунд алхаж, тэр үеийн хүмүүсийн өдөр тутмын амьдралыг нүдээрээ харж, бодит болсон болон үлгэрийн үйл явдлуудтай өмнө нь төсөөлж ч байгаагүйгээр танилцаж болно.



Газар зүй 3D үзэгдэл – Ангараг гаригийг судлах программ

Байгаль ертөнцийн нууц
Сансраар аялан, нарны системийн талаар суралцаж, газар дэлхий дээрх байгалийн гайхамшигууд, байгалийн хууль, жам, нууцлаг ертөнцтэй танилцаж болно.

таблетад зориулсан

mozaBook



мобайл төхөөрөмжид зориулсан mozaBook

Сурагчид гэр, сургууль дээрээ ухаалаг төхөөрөмжийнхөө тусламжтайгаар сурах бичгүүдээ нээн үзэх боломжтой.



Сурагчид таблетад зориулсан аппликейшны тусламжтайгаар Windows, Android болон iOS үйлдлийн системтэй таблетээр нэмэлт хэрэгслээр баяжуулсан сурах бичгээ ашиглах боломжтой. Цахим сурах бичгүүдийг татаж аваад онлайн, офлайн ямар ч горимоор ашиглаж болдог.

MOZAIK



3D үзэгдэл дэхь виртуал бодит байдал

3D үзэгдлүүдийг сурагчид гар утсаараа виртуалаар ч үзэх боломжтой. Хэрвээ зориулалтын VR нүдний шилэнд гар утсаа байрлуулбал тэр дорoo эртний Афинд, Шекспирийн театрт, эсвэл бүр сарны гадаргуу дээр ч зочлох боломжтой болно.



Техникийн шаардлагууд:

- гироскоп бүхий ухаалаг утас
- VR нүдний шил
- mozaWeb бүртгэл
- үнэ төлбөргүй татаж авах боломжтой mozaik3D аппликейшн



Цахим нийтлэлүүдийг уншихад интерактив агуулгын жагсаалт тусална. Ном, дэвтрүүдийн хуудсан дээр зургийн хэрэгслийг ашиглан зурж, бичвэрийг тодруулах боломжтой. Систем нь сурагчид шинэ гэрийн даалгавар ирсэн талаар мэдэгддэг ба даалгавраа хийгээд багшдаа буцаан илгээж болно.

mozaBook Editor



онлайн цахим сурах бичиг засварлагч систем

Аль ч хэвлэлийн газар өөрийн хэвлэсэн сурах бичгийн PDF хувилбарыг mozaBook Editor-д байршуулж, шууд интерактив цахим сурах бичиг болгон хөрвүүлэх боломжтой. Систем нь хэвлэлийн газар бүрт бүрмөсөн тусгаарласан, дангаар хандах боломжийг олгодог бөгөөд ингэснээр хэвлэлийн газар бүр зөвхөн өөрийн хэвлэлд хандах эрхтэй байх болно.

MOZAIK

Цахим сурах бичиг үүсгэх

Эхний алхамд бид багш нар болон сурагчдын хэрэглэдэг хэвлэмэл сурах бичгүүдийн цахим файлуудыг mozaBook Editor онлайн цахим сурах бичиг засварлах платформд байршуулдаг. Үүний дараа Mozaik Education-ий бүтээсэн мянга гаруй интерактив 3D үзэгдэл, хэдэн зуун видео, аудио, зураг, дасгал болон бусад материалыг агуулдаг цахим боловсролын медиа сангаас нэмэлт агуулгуудыг уг сурах бичгүүдэд нэмж оруулдаг.



mozaBook Editor нь медиа санд, өөрийн болон интернэтээс олсон агуулгуудыг оруулах боломжийг ч олгодог. Ингэж баяжуулсан цахим номуудаас хичээлийн явцад интерактив самбарт хэрэглэх, гэртээ интернэт орчинд хичээлээ хийх, эсвэл iOS, Windows болон Android үйлдлийн системтэй таблет дээр хэрэглэх зориулалтаасаа хамааран төрөл бүрийн сурах бичгийн багцыг үүсгэдэг.

mozaBook Editor

Онлайн цахим сурах бичиг засварлагч систем

Олгох боломжууд

- PDF файл (сурах бичиг) импортлох
- Тухайн хуудасны агуулгыг параграф, зураг гэх мэтчилэн хэсгүүдэд салгаж, томруулан харахад зориулж засварлах
- Нийтлэлд интерактив агуулгыг оруулах
- Интерактив агуулгын жагсаалт үүсгэх
- Цахим сурах бичгийн багц үүсгэх (mozaBook, mozaWeb, iOS, Android)
- Засварлагчдад үүрэг даалгаврыг хуваарилан олгох
- Засвар хийсэн статистик мэдээлэл
- Цахим сурах бичгийн багцын удирдлага, зохион байгуулалт
- Цахим сурах бичгийн багцын удирдлага
- Цахим сурах бичгийн багцын төлөв байдлын тайлан

mozaLearn нутагшуулагч

mozaLearn системийн онлайн орчуулгын болон нутагшуулах платформ

Олгох боломжууд

Цаашид тухайн хэлээр нутагшуулах хүсэлтэй байгаа бол mozaBook болон mozaWeb-ийн интерфэйс, хэлний элементүүдийн орчуулга, аливаа засварыг mozaLearn нутагшуулах платформ дээр хийж болно.

- mozaBook: цэсний тогтолцоо ба хэрэглэгчийн интерфэйс
- mozaWeb: цэсний тогтолцоо ба хэрэглэгчийн интерфэйс
- mozaTools: өгөгдлийн сан ба хэрэглэгчийн интерфэйс
- 3D үзэгдэл: цэсний тогтолцоо ба үзэгдлийн бичвэр агуулгууд

Медиа сан

Хичээлд бүрд зориулсан интерактив сургалтын агуулгууд

Агуулгын төрлүүд

- Интерактив 3D үзэгдлүүд (1300 гаруй)
- Сургалтын видеонууд (1000 гаруй)
- Сургалтын хэрэгсэл болон тоглоомууд (120 гаруй)
- Танин мэдэхүйн зургийн цуглуулга
- Хөгжмийн бүтээл болон аудио материалууд


Mozaik Education болон түүний түншүүд нь боловсролын шинэ агуулгыг байнга хөгжүүлдэг тул Медиа сан хурдтайгаар өргөжиж байгаа. Бүх агуулгыг манай www.mozaweb.com вэб хуудаснаас үзэх боломжтой.



mozaik3D app

3D үзүүлэн таны утас болон таблет дээр

Бид аппликейшнуудаа ялангуяа 8-18 насны сурагчдын хэрэглээнд санал болгож байна. Түүх, урлагийн түүх, технологи, физик, математик, биологи, хими, болон газар зүйн сэдвүүдэд холбогдох интерактив үзэгдлүүд нь суралцах үйл явцыг адал явдал болгон хувиргадаг.




3D үзэгдлүүд нь 3D гаруй хэлээр орчуулагдсан бөгөөд энэ нь гадаад хэл эзэмших, дадлага хийх гайхалтай боломжийг олгодог.



Манай интерактив 3D үзэгдлүүдийг эргүүлж, томруулж, урьдчилан тохируулсан өнцгөөс харж болно. Урьдчилан тодорхойлсон харагдацын тусламжтайгаар үзэгдэл дотор хялбархан шилжих боломжтой.

Манай 3D үзэгдлүүдийн ихэнх нь хүүрнэл, анимейшнийг агуулдаг. Эдгээр нь мөн шошголох, хөгжилтэй хөдөлгөөнт асуулт хариултуудыг ч бас агуулдаг.



3D үзэгдлүүдийн тусламжтайгаар та интерактив цахим номынхоо хуудсуудыг амилуулах болно.





Бүх Mozaik 3D үзэгдлийг стереоскоп горимд шилжүүлж, гайхалтай виртуал бодит байдлыг мэдрэх боломжтой. Вавилон хотоор тойрон алхах эсвэл саран дээр буух нь ердөө л ганц товшилтын зайд байдаг.

Зарим 3D үзэгдлүүд нь тойрон алхах функцийг агуулдаг бөгөөд энэ нь виртуал джойстик ашиглан үзэгдлийг өөрөө судлах боломжийг танд олгоно.



mozaik3D app-ын (бүх төрлийн VR нүдний шилд тохирсон, iOS ба Android төхөөрөмж дээр ажилладаг) тусламжтайгаар захиалгчид нь манай бүх 3D үзэгдлийг сонирхон үзэх боломжтой.




Та утсаа VR нүдний шилэнд хиймэгц хүний биеийн дотор орж аялах эсвэл жишээ нь навчны бүтцийг судлах боломжтой болно.



Matek ann

ухаалаг төхөөрөмж ашиглан тэгшитгэл бодох

Matek боловсролын аппликейшн ашиглан хамгийн төвөгтэй тэгшитгэлүүдийг бодож, зөв хариуг хэрхэн гаргахыг ойлгож авах боломжтой. Тэгшитгэлийн зургийг дарж, эсвэл дэлгэцэн дээр гараараа бичвэл аппликейшн танд тэгшитгэлийн бодолтыг алхам алхмаар үзүүлж хөтлөнө.



Дасгалыг сурах бичгээс, эсвэл дасгал ажлын дэвтрээс ухаалаг утасны камера ашиглан эсвэл төхөөрөмжийнхөө дэлгэцэн дээр гараар бичин оруулах боломжтой байдаг.



Бодолтыг алхам алхмаар нь задлан дагаж хийж ч болно. Өөрөө бодож чадахаар бол бие даан үргэлжлүүлэн бодож, гацах үе гарвал алхам бүрт зөвлөгөө авч ч болдог. Дасгалын хялбаршуулсан бодолтыг бүхлээр нь харах, эсвэл ганц товшилтоор илүү дэлгэрэнгүй тайлбар авах боломжтой.

Fizika ann

мобайл төхөөрөмж дээр туршилт хийх

Fizika аппликейшн нь хэрэглэгч хялбар бөгөөд сонирхолтой байдлаар тоглонгоо хэрэглэх боломжтой. Тоглонгоо суралцаж, хүрээлэн буй зүйлс хэрхэн ажилладаг болохыг ойлгож аваарай. Уг аппликейшнийг ухаалаг утас, сургуулийн интерактив самбар дээр ч ашиглаж болно.




Механик процессыг ажиглан, хэдэн товшилтоор загварчлаад, төхөөрөмж дээрээ хүссэнээрээ тоглууларай.

Үйл явц хэрхэн явагддаг болохыг шалган үзэх боломжийг олгож, ямар физик үзэгдэл дээр үндэслэдгийг ойлгож авах боломжтой болно.



Туршилтын явцад биетүүдийн шинж чанарыг өөрчилж, нөхцөл өөрчлөгдвөл юу болох талаар мэдэж авах боломжтой.

Үйл явцыг ойлгох хамгийн хялбар арга бол график ашиглах явдал юм. Виртуал туршилтанд дүн шинжилгээ хийх графикуудыг ганц товшилтоор үүсгэн, физик үзэгдлүүдтэй нэгэн зэрэг биеийн хөдөлгөөнийг дүрслэх боломжтой.



LabCamera



Бодит цагийн видео шинжилгээ

LabCamera нь сурагчдад ухаалаг төхөөрөмжийн камер эсвэл веб камер ашиглан туршилт хийх боломжийг олгодог шинжлэх ухааны туршилтын программ юм. Энэ программ нь бага зардлаар STEM сургалтын хөтөлбөрт тохируулан, шинжлэх ухааны судалгаа хийхэд тусладаг.



LabCamera нь туршилт хийх, ажиглах, асуудлыг шийдвэрлэх чадвар, шүүн тунгаах сэтгэлгээ, дедуктив тунгаан бодох чадваруудыг хөгжүүлдэг. LabCamera нь шинжлэх ухааны бүх сэдвийг хамарсан 7 модультай.



MZAIK


Time Lapse

Time Lapse функц нь үүл үүсэх болон нүүх, мөс хайлах, ургамал ургах гэх мэт байгаль дахь урт удаан үйл явцыг ажиглаж, илүү сайн ойлгоход тусалдаг.



Кинематик

Кинематик модуль нь веб камераар харуулах зураг эсвэл видео бичлэг ашиглан хөдөлгөөнийг шинжилдэг бөгөөд нэгэн зэрэг 3 биеийн хөдөлгөөнийг хянах боломжтой.



Тагнуулын камер

Тагнуулын камер нь байгалийн ховор, гоц агшнуудыг буулган авах боломжийг танд олгоно. Ажиллагаа нь хөдөлгөөн мэдрэгч бүхий камерын ажиллагаатай ижил байдаг.



Универсаль бүртгэл хөтлөгч

Уг модуль нь дижитал, аналог дэлгэцтэй, эсвэл шингэн баганат аливаа хэмжих хэрэгслийн өгөгдлийг суурилуулсан камераараа дамжуулан компьютерт уншуулах замаар бүртгэх чадвартай байдаг.

Микроскоп

Микроскоп модулын тусламжтайгаар микроскопын шинжилгээ хийх, эсвэл зай, өнцөг болон гадаргуугийн талбайг хэмжих боломжтой.

Зам хайгч

Зам хайгч модуль нь камераар авсан зураг, дээр харагдах хөдөлгөөнийг шинжилж, газрын зураг дээр буулгадаг. Программ нь харахад санаандгүй юм шиг хөдөлгөөнүүд дотроос дахин давтагдах замыг арай хурц өнгөөр тэмдэглэнэ.

График уриалга

Энэхүү тоглоомын аппликейшн нь графикуудыг ойлгоход тусалдаг. Зорилго нь нэг муруйгаар дүрсэлсэн хөдөлгөөнийг камерын өмнө өөрсдийн хөдөлгөөнөөрөө давтаж үзүүлэх явдал юм.

Долоо хоногийн давтлагын хэрэгсэл

хиймэл оюун ухаан боловсролд

Долоо хоног тутмын давтлага нь аль ч улсын сургалтын хөтөлбөрт тусгагдсан сэдвүүдийн аль хэсгийг судалж байгаа дээр үндэслэн дасгалуудыг үүсгэдэг цогц хэрэгсэл юм. Энэ нь багш, сурагчдад бие даан бодож болох, хүн бүрд тусгайлан үүсгэсэн дасгалын хуудсууд дээр ажиллан, хичээлээ давтаж, долоо хоног бүр үр дүнгээ хянах боломж олгодог.



MAT - 7 Week 35 Check

1. Frequency

A dice has been thrown several times. The outcomes are the following:

Based on this, what was the frequency of throwing a 1?

A 1 B 4 C 3 D 0

2. Adding fractions

Do the following calculation.

$$-\frac{171}{6} + \left(-\frac{80}{3}\right)$$

A $-\frac{271}{6}$ B $-\frac{325}{6}$ C $-\frac{301}{6}$ D $-\frac{331}{6}$

3. Diagram

Observe the diagram and find out the average temperature of the specified week.

A 7 °C B 10 °C C 11 °C D 9 °C

Долоо хоног тутмын давтлагын хэрэгслийг ашиглан хичээлийн жилийн турш болон зуны амралтын үеэр ч хичээлээ давтах боломжтой. Хэрэглэгч хичээл, анги, хичээлийн жил болон долоо хоногийг сонгох боломжтой байдаг.

Сургалтын хөтөлбөрт үндэслэн уг программ нь сурагч бүрт зориулсан өөрөө бодож, шалгаж болох тусгай, дасгалын хуудсуудыг үүсгэдэг. Өмнө нь бодсон дасгалуудын хариуг программын тусламжтайгаар эргэн хянах боломжтой.

Сурагч бодлого бодож байхдаа чадахгүй бол Өгүүлбэртэй бодлого хэрэгслээс тусламж аван, бодлого бүрийн шийдлийг алхам алхмаар харж болно.

Өгүүлбэртэй бодлогын хэрэгсэл

Энэхүү хэрэгсэл нь байгалийн шинжлэх ухааны тухайн салбарын хууль зарчмыг мэддэг бөгөөд дасгал үүсгэх, бодохдоо эдгээрийг ашиглаж болно. Энэ нь өөр өөр дасгалууд хэдийг ч үүсгэж, бодох явцыг нь алхам алхмаар харуулах боломжтой.

Боломжууд:

- Байгалийн шинжлэх ухаанд хамаарах дасгалын төрлүүдийн сэдэвчилсэн ангиллыг багтаасан
- Өгсөн сэдвээр аль ч хэлээр дасгал үүсгэх чадвартай (тусгай тохиролцооны дагуу тухайн улсын хэлээр нутагшуулах боломжтой)
- Аливаа үүсгэсэн дасгалын шийдлийг алхам алхмаар хэрэглэгчид танилцуулах боломжтой
- Багш нар сурагчдад зориулан дасгалын хуудас үүсгэх боломжтой

Хичээлийн хөтөлбөрийн нэгжүүдийг тухайн улсын сургалтын нэгдсэн хөтөлбөрөөр судлах цаг хугацаанд нь тохируулан боловсруулдаг.

Тухайн улсын сургалтын хөтөлбөр болон сонгосон хичээлийн цагийн хуваарилалтын дагуу ээлжит долоо хоногийн дасгалын хуудсыг үүсгэдэг.

Долоо хоногийн давтлагын хэрэгслийн ашиг тус:

- хичээлээ байнга давтах боломжоор хангана
- сурагч бүрт тусгайлан зориулсан тест үүсгэнэ
- дасгалуудыг шийдвэрлэхэд хэрэглэгчдэд тусламж өгнө
- үр дүнгээ хянахад тусална
- тухайн улсын сургалтын хөтөлбөрт дасгалын хуудсуудын сэдэв, судлах цагийг тохируулна

Word problems

The area of a triangle is 25 m^2 , and its perimeter is $1,500 \text{ cm}$. What is the radius of the circle inscribed in the triangle?

steps of the solution

1. First make a drawing, collect the data and then write down the quantities you want to calculate. If necessary convert the units into common metric units.

- 2.
3. $A = 25 \text{ m}^2$ area
4. $P = 1,500 \text{ cm} = 15 \text{ m}$ length
5. $r = ?$ length
6. Write down the formula you are using. If necessary, rearrange the formula to solve for the unknown quantity.
7. $A = \frac{P \cdot r}{2}$ Area-perimeter-inner circle radius formula of the triangle
8. $r = \frac{2 \cdot A}{P}$
9. Substitute into the formula and do the calculations.
10. $r = \frac{2 \cdot \text{m}^2}{\text{m}} = \text{m}$

The radius of the circle inscribed in the triangle is m.

МЭДЛЭГИЙН граф


холбогдох бүх агуулгууд ганц товшилтоор

Боловсролын бүх материалууд ном, сурах бичиг, хичээлийн агуулга цахим хичээл, 3D үзэгдэл, видео, интерактив 3D ухаалаг ном нь нэгдсэн сүлжээ болон өөр хоорондоо холбогдон нэгдсэн агуулгын системийг бий болгодог. Агуулгын графыг аль ч улсын сургалтын хөтөлбөрт тохируулж болох бөгөөд программд илүү зохицох, сэдэвтэй холбогдох материалыг санал болгох боломж олгодог.



- интерактив цахим сурах бичгүүд
- хамтарч ажиллахад зориулсан үзэмжтэй сургалтын материалууд
- VR функцтэй интерактив 3D үзэгдлүүдүүд
- нас болон хичээлээр ангилсан сургалтын хэрэгслүүд
- шинэ мэдлэг олгох сургалтын видеонууд
- хичээлийг нэмж баяжуулах 3D ухаалаг номууд

Агуулгын граф нь хэрэглэгчдэд нэг агуулгаас нөгөө рүү, холбогдох сэдвүүдийн хооронд шилжих боломжийг олгодог. Хэрэглэгч тус бүрийн сонирголоос хамааран тус тусад нь зориулсан тусгай сурах хөтөлбөрийг бий болгох боломжтой.




Графын холболтын бүтцийг тухайн улсын шаардлагад нийцүүлэн өөрчлөх боломжтой.

Цахим хичээлүүд

хичээлийн төлөвлөлтөд үндэслэсэн хамтран суралцахад чиглэсэн материалууд



Хэвлэмэл сурах бичиг болон дижитал боловсролыг холбож, дижитал анги руу шилжихэд туслах хамгийн сүүлийн үеийн материалууд.




Олж авсан мэдээллийг боловсруулах нь сурагчдын идэвхтэй оролцоо, туршлагад суурилсан мэдлэг, хамтынн ажиллагаа дээр суурилдаг. Шинэ асуудлуудын шийдлийг сурагчид хамтаараа хайж олоходг чиглүүлж, зөвлөдөг.

Хичээлийн агуулгууд нь багшийн чиглүүлэгээр сурагчдын нийгэмшлийн болон цахим ур чадвар, хамтран ажиллах чадварыг сайжруулдаг. Товчхондоо хиймэл оюун ухааны ертөнцөд ирээдүй хойч үеийнхэнд зайлиггүй шаардлагатай ур чадваруудыг хөгжүүлэхийг урьтал болгодог.

MOZAIK

Цахим хичээлүүдийг хичээлээр, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, эсвэл интеграци хичээл болгон ашиглаж болно. Цахим хичээлүүд дэхь интерактив 3D үзэгдэл, сургалтын видео, дасгалын хуудсууд нь судалсан хичээлээ ойлгож, эзэмшихэд тусладаг.




Онцлогууд

- Хичээлийн төлөвлөлтөд үндэслэсэн хамтран суралцахад чиглэсэн сургалтын материалууд.
- Хичээл хоорондын интеграци (жишээ нь: байгалийн шинжлэх ухаанууд, математик, түүх).
- Ойлгоход хялбар байдлаар бичсэн байдаг тул суралцах явцыг хөнгөвчилж өгнө.



Үзэмжтэй агуулгуудыг интерактив самбар, таблет болон ухаалаг гар утсан дээр ашиглах боломжтой бөгөөд багш, сурагчдын цахим ур чадварыг сайжруулдаг.

Багш нар сургалтын хөтөлбөрөө үр дүнтэй боловсруулахад туслах хичээлийн төлөвлөгөөтэй танилцах боломжтой байдаг. Уг төлөвлөгөө нь цаг хуваарилах, сургалтын зорилгыг хэрэгжүүлэх, хичээлийн үр дүнтэй үйл ажиллагааны талаар санааг өгдөг.




3D ухаалаг номнууд

интерактив 3D ухаалаг номууд



20 боть бүхий цуврал нь tozaWeb дээр байдаг 3D үзэгдлүүдэд үндэслэсэн. 3D ухаалаг номууд нь анимейшний дүрслэлийг ойлгоход хялбар тайлбар бичвэртэй хослуулсан, хэд хэдэн хичээлийн сэдвийг агуулсан байдаг. Уг цувралыг олон хэлээр унших боломжтой.



Цуврал номын ботуудын тусламжтайгаар байгалийн ухаан, техник, түүх архитектурын ертөнцөд орж алхах боломжтой.


Хуудсууд дээр байгаа QR кодыг уншуулснаар 3D үзэгдлүүдийг ганц товшилтоор нээх боломжтой болох ба тухайн сэдвийг сайтар судлах интерактив боломж сурагчдад олгоно.

Үзэгдлүүдийн виртуал ертөнцөд VR нүдний шилний тусламжтайгаар тойрон алхаж, номонд уншсан зүйлсээ нүдээр харах боломжтой юм.

Нийтлэлүүд нь хэвлэмэл ном болон виртуал ертөнцийн давуу талуудыг орчин үед мэдлэгийг олгох зорилгоор нэгтгэсэн байдгаараа өвөрмөц юм.

3D CLICK N' LEARN

3D ухаалаг ном нь хичээл болон гэртээ хэрэглэхэд зориулсан, мөн олж авсан мэдлэгээ тоглоомын хэлбэрээр өргөжүүлэхэд тусалдаг.




Сурагчид зөвхөн өнгөрсөн болон ирээдүйд болох үйл явдлуудтай танилцахаас гадна бичил ертөнц, хүний бие дотор ба алсын одоор ч аялах болно.

Цувралыг хэнд санал болгох вэ?

- орчин үеийн, сайн чанарын номуудаар номын сангаа баяжуулахыг хүссэн, эсвэл сурагчдадаа ном бэлэглэхийг хүссэн сургуулиудад
- сурагчдадаа урам зориг өгөхийг хүссэн, цахим хэрэгслийг хичээл дээрээ хэрхэн ашиглах талаар шинэ санаа хэрэгтэй байгаа багш нарт
- ном унших дуртай, цахим анимейшн сонирхдог хүүхдүүдэд
- хүүхдүүдээ цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэхийн зэрэгцээ тоглонгоо суралцаж, үзэмжтэй сургалтын материалуудыг сонирхон үзээсэй гэж хүссэн эцэг эхчүүдэд



3D үзэгдлүүдийг үнэ төлбөргүйгээр татаж авах боломжтой tozaBook аппликейшнээр нээж болно.



mozaLog

сургуулийн цахим бүртгэл

Манай компаний mozaLog цахим сургуулийн бүртгэл нь нэгдмэл ганц интерфэйс дээр сургуулийн өдөр тутмын бүртгэл, зохион байгуулалтын ажлыг хөтөлж, удирдаж болох мэдээллийн систем юм. mozaLog-ийг ашигласнаар уламжлалт цаасан дээрх бүртгэл хөтлөлтийг халж, багш нарын удирдлага, зохион байгуулалтын ажлын ачааллыг мэдэгдэхүйц хөнгөлж өгөх боломжтой болно.



MOZAIK

Өргөн зурвасын серверүүд нь сургуулийн цахим бүртгэлийн үйл ажиллагааг 24 цагийн турш хангадаг бөгөөд ингэснээр mozaLog-ийг интернетээр олон мянган хүн нэгэн зэрэг ашиглах боломжтой.

#	Students name	Mark	L. term					Average	New mark	Final-term mark
			Sep	Oct	Nov	Dec	Jan			
1.	Abbott Anthony (TMM)	8.A	3	4	5	2.4	3.6	5		
2.	Beck Jacob	8.A	5	5.4	5	5.4	4.67	5		
3.	Bradley Violet	8.A	5	5	5	5.5	5	5		
4.	Campbell Timothy	8.A	4	4	5	5.5	4.6	5		
5.	Cannon Luke	8.A				4.5555	4.8	5		
6.	Cooper Deborah (SH)	8.A	5	5.5	5.5	5.5	5	4		
7.	Goodman Pat	8.A	4	3.4	5	4.5	4.17	5		
8.	Kall Alan	8.A	4	5.5	5.5	4.55	4.75	5		
9.	Henderson Cathy	8.A	5	5.5	5.5	5.5	5	5		
10.	James Helen	8.A	5	5	5.5	5.5	5	4		
11.	Lee Mary	8.A	5	4.5	5	4	4.6	5		
12.	Marsh Terrence	8.A	5	3	5	4.54	4.33	5		
13.	Moore Phillip	8.A	5	5.5	5	5.5	5	5		

Уян хатан, олон талтай

Цахим бүртгэл нь цаасан журналын нэг адилаар өдөр бүр хөтөлж болох хичээлий ирц болон үнэлгээний ахиц, дүнгийн талаар мэдээлэл оруулах зориулалттай. Мөндугуйлангуудыг ч бас үүсгэх боломжтой.

- Хичээл таслалтаас гадна хоцролт, чөлөө авсан, хичээлийн хэрэгсэл дутуу байдлыг ч бас тэмдэглэх боломжтой. Тест бичээгүй сурагчдын талаархи мэдээллийг ч бас авч болно.
- Олон төрлийн үнэлгээ үнэлгээний дунджид өөр өөр байдлаар нөлөөлөхөөр оруулж ч болно.

A/B	Monday	Tuesday	Wednesday	Thursday	Friday	Saturday	Sunday
	29. Monday	30. Tuesday Teacher staff meeting	31. Wednesday	1. Thursday Commencement ceremony	2. Friday	3. Holiday	4. Holiday
	5. Monday Parent-teacher conference	6. Tuesday	7. Wednesday	8. Thursday	9. Friday	10. Holiday	11. Holiday
	12. Monday	13. Tuesday	14. Wednesday Back-to-school survey	15. Thursday	16. Friday	17. Holiday Field trip	18. Holiday Field trip
	19. Monday	20. Tuesday	21. Wednesday	22. Thursday	23. Friday ICT-training	24. Holiday	25. Holiday
	26. Monday Open day	27. Tuesday	28. Wednesday	29. Thursday	30. Friday		

Хялбар арга хөтлөх



Цахим бүртгэл нь хичээлээс гадуурхи үйл ажиллагааг бүртгэх боломжтой. Жишээлбэл сургуулийн баяр ёслол, аялал зугаалга гэх мэт.

Үнэлгээний статистик

Ахицын тэмдэглэлээс багш нар ангиуд хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөний дагуу ахиж байгаа эсэхийг хянах боломжтой. Ингэснээр багш нарыг цахим бүртгэлийг байнга хөтлөх хариуцлагыг бий болгодог.

Teacher	Sep	Oct	Nov	Dec	Jan	1st term	Jan	Feb	Mar	Apr	May	Jun	2nd term	Together
All Zein Khaddam	66/68	62/62	94/94	79/79	60/62	359/361								359/361
Apple Ingrid	41/41	42/42	44/44	36/36	28/26	191/199								191/199
Bernath, Gregory	76/76	92/92	94/94	46/46	49/58	277/281								277/281
Berd, Zachary	70/70	57/57	74/74	64/64	50/60	318/325								318/325
ft9 blond, Andrew	97/97	87/87	87/87	57/57	35/45	363/372								363/372
Bok, Annas	76/76	78/78	97/97	56/56	57/77	364/384								364/384
Bosnik, Kate	85/85	80/80	90/90	83/83	55/71	393/409								393/409
hm1 Bozovich, Martin	99/99	90/90	106/106	67/67	62/62	444/444								444/444
ft2 Charles, Andrew	26/26	84/84	74/74	59/59	48/53	291/296								291/296
Chikora, Zach	91/91	93/93	66/66	79/79	68/80	399/411								399/411
Farnceath, Apatha	99/99	90/90	97/97	80/80	78/78	444/444								444/444
Farrow, Igor	40/40	29/29	43/43	12/28	8/23	120/159								120/159
Feky, Charles	1/5	6/8	8/8	2/4	2/6	19/31								19/31
Fisherman, Karl	93/93	96/96	102/102	68/68	48/73	409/434								409/434
Foam, Adele	32/32	27/27	32/32	21/24	20/23	132/138								132/138

- Сурагчдын мэдээллийг нэг бүрчлэн оруулах шаардлагагүй, программ нь төв мэдээллийн системээс мэдээллийг импортлох боломжтой.
- mozaLog-ийн тусламжтайгаар график диаграмаар дүрслэн үзүүлсэн судалгаа, танилцуулгыг үүсгэх боломжтой байдаг.



Эцэг эхчүүдтэй холбоо тогтоох

Цахим бүртгэлийн тусламжтайгаар эцэг эхчүүд хүүхдийнхээ хэр үр дүнтэй суралцаж байгааг өдөр тутамд хянаж, хичээл тасралт, төлөвшил, хичээлийн идэвхийн талаар мэдээлэл авч байх боломжтой. Эцэг эхчүүд хүсвэл хүүхдийнхээ талаархи бүх тэмдэглэлийг цахим шуудангаар авах боломжтой.

Багш нар сургуулийн үйл ажиллагаа, зугаалга, эсвэл бүр шалгалт сорилын товыг урьдчилан мэдээлэх боломжтой бөгөөд сурагч, эцэг эхчүүд удахгүй болох зүйлсийн талаар цаг бүрт нь мэдэж авна.

Сургуулийн вэб хуудсан дахь цахим бүртгэл

Манай mozaPortal үйлчилгээ нь одоо ч амьдрал дээр үр дүнтэйгээр ашиглагдаж буй сургуулийн хэрэгцээнд зориулсан тусгай вэб хуудас юм. Цэсийг нь тухайн сургуулийн хэрэгцээнд тохируулан өөрчлөх боломжтой ба хүссэн агуулгаа байршуулах боломжтой байдаг.



- Манай сургуулийн цахим бүртгэлийн системийг mozaPortal сургуулийн вэб хуудасны үйлчилгээний хамтаар ч захиалах боломжтой.
- Энэ тохиолдолд mozaLog нь сургуулийн вэб хуудасны нэг хэсэг нь болж цэснээс шууд хандах боломжтой байдаг.



Ангийн ажил

анги удирдлага

Багш нар тозаВook-д виртуал анги үүсгэн, сурагчдаа урьж болно. Сурагчид багшийн эхлүүлсэн ангийн ажилд өөрсдийн таблетээрээ нэгдэх боломжтой. Багшийн компьютер болон таблет хооронд холбогдоход интернэт шаардлагагүй, харин зөвхөн нэг ижил Wi-Fi сүлжээнд холбогдсон байхад л хангалттай байдаг.



Багш нар сурах бичгийн хуудсыг сурагчдын төхөөрөмж рүү шууд хуваалцах боломжтой. Үүнээс гадна багш нь сурагчдад даалгавар, дасгалын хуудас, видео эсвэл зураг илгээж болно. Мөн багш нар дасгалын хуудасны гүйцэтгэлийг хянаж, сурагчдын хариултыг компьютер дээрээ шалгах боломжтой.

MOZAIK

Багш нь ангийн ажилд хэн холбогдсон, хэн холбогдоогүй байгааг байнга харж байдаг.

Сурагч бүр хэр ахицтай ажиллаж байгааг хянахын тулд төхөөрөмжөөс нь тухайн үеийн дэлгэцийн агшинг харах боломжтой.



Багш нь...

- зураг, дүрслэл, дасгалын дэвтрийг сурагчдын төхөөрөмж рүү илгээх
- ганцаарчилсан, бүлэг нийтээр даалгавар өгөх
- дугуйлан зохион байгуулж, удирдаж, хянах
- даалгаврын гүйцэтгэлийн явцыг хянах
- илгээсэн, автоматаар үнэлэгдсэн хариултуудыг харах
- дүнгийн статистикийг хүлээн авах боломжтой.



Сурагчид авсан даалгавраа өөрсдийн төхөөрөмж дээрээ ганцаарчлан, эсвэл багаар гүйцэтгэж, хариултыг буцаан илгээнэ.

Илгээсэн хариултуудыг систем автоматаар үнэлж, үнэлгээний статистик гаргадаг тул багш нар сурагчдын гүйцэтгэлийг маш хялбархнаар дүгнэх боломжтой.


ГЭРИЙН ДААЛГАВАР

онлайнаар хийж болох даалгаврууд



Багш нар тозаBook-ийн дасгал засварлагчаар үүсгэсэн дасгалуудыг сурагчдад гэрийн даалгавар болгон өгөх боломжтой.

Программын тусламжтайгаар анги, дугуйлан болон сурагч тус бүрт өгсөн даалгавруудыг хянаж, удирдах боломжтой болно.



Багш нар тозаWeb платформоор бүлгүүдийг удирдаж, хийж дууссан гэрийн даалгаврын талаарх бүх мэдээллийг харах боломжтой. Эдгээр функцэд тозаBook-ийн Гэрийн даалгавар самбар дээрээс ч шууд хандах боломжтой.



Сурагчдад гэрийн даалгавар, даалгаврын сэдэв, эцсийн хугацааны талаар цахим шуудангаар мэдэгдэнэ. Сурагчид гэрийн даалгавраа онлайнаар нээж, хийх боломжтой.



Давуу талууд нь:

- Багш нар дасгал засварлагчийн тусламжтайгаар дасгалуудыг хялбархан үүсгэх боломжтой бөгөөд үүндээ медиа сангийн нэмэлт интерактив агуулгыг ашиглах боломжтой.
- Систем нь тохируулсан болон буцаан илгээсэн гэрийн даалгаврыг бүртгэдэг тул гэрийн даалгаврын гүйцэтгэлийг хялбархан хянаж, шалгах боломжтой.
- Программ нь хариултыг автоматаар шалган үр дүнгийн статистикийг үүсгэж, сурагчдын гүйцэтгэлийг үнэлэх, харьцуулах боломжийг олгодог.




Дасгалуудыг дурын интернет хөтөч ашиглан онлайнаар гүйцэтгэх боломжтой.

Хичээлийн танхимд



Багш ухаалаг самбар дээр бүх хичээлд интерактив хэрэгслүүд, 3D-үзэгдэл, видео болон бусад агуулгын тусламжтайгаар үзэмжтэй, динамик үзүүлэнг бэлтгэн ашиглах боломжтой. Мөн хичээл дээр болон гэртээ хийхэд зориулсан дасгал, даалгавруудыг ч бас үүсгэх боломжтой юм.



Хичээлийн танхимд юу шаардагдах вэ?

mozaBook-ийг р ашиглахад Mozaik TEACHER эсвэл mozaBook CLASSROOM лиценз (ашиглах эрх) авах шаардлагатай.

Сурагчдын таблет дээр юу шаардагдах вэ?

Сурагчид багшийн үүсгэсэн ангид нэгдэн орж, зураг, интерактив аппликейш, бичвэр мэдээлэл болон дасгал ажлын хуудсыг хүлээн авах, мөн тэдэнд илгээсэн дасгал, даалгаврыг хийхэд Mozaik STUDENT хэрэглэгчийн эрх шаардлагатай.

Сурагчдад Mozaik STUDENT эрхтэй болсноор mozaBook Windows программыг компьютер дээрээ суулгах, mozaBook Android, iOS app-ыг гар утас, таблетд татаж авах, мөн mozaWeb сургалтын порталыг ашиглах боломжтой. Хэрэглэгчийн эрх буюу бүртгэлээрээ Mozaik системийн бүх агуулгад тохиромжтой төхөөрөмжөөс хандах боломжтой болно.



Android болон iOS системд зориулсан аппликейшнууд нь App Store, Google Play -д байгаа.

Mozaik TEACHER лиценз

Нэг багш mozaBook болон mozaWeb-ийг хэд хэдэн төхөөрөмж дээр ашиглах боломжтой хэрэглэгчийн лиценз.

mozaBook CLASSROOM лиценз

mozaBook-ийг нэг төхөөрөмжөөр олон багш ашиглах боломжтой, төхөөрөмжд суурилсан лиценз.

Альч лицензээр медиа сангийн бүх агуулгад хандаж болох бөгөөд интерактив дасгалын дэвтэр (үзүүлэн)-ийг үүсгэн үүлэн технологиор дамжуулан бусад багш нар, сурагчидтай хуваалцах боломжтой.

Сурагчид хичээлийн явцад компьютер, таблет ашигладаг бол „classroom management” функцийг ашиглан дасгалууд, видео, зураг болон бусад сургалтын материалуудыг хуваалцах боломжтой байдаг.



Дэлгэрэнгүй мэдээллийг авахын тулд www.mozaweb.com хуудсаар зочлоорой.

ГЭРТЭЭ

tozaBook-ийг ашиглан багш нар гэртэй тав тухтайгаар хичээлээ төлөвлөн бэлтгэх боломжтой. Сурагчид tozaWeb-ийг гэртээ хичээлээ хийхдээ ашиглаж болно. Гэрийн даалгавраа хийж, бие даан хичээлээ давтах ч боломжтой бөгөөд интернет холболт, вэб хөтөч л шаардагдана.

Багш нар tozaBook-ийг гэртээ хэрхэн ашиглаж болох вэ?

Багш нар гэрийнхээ компьютер дээр цахим сурах бичгүүдийг интерактив агуулгаар баяжуулан, үзүүлэн бэлтгэж, tozaBook-ийн сургалтын хэрэгслүүдээр туршилтын симуляци хийж хичээлийн сэдэвт тохирох лабораторийн багцыг бий болгох боломжтой. Mozaik TEACHER эрхээр нэвтэрч хичээлийн танхим, өөр газраас ч, шаардлага хангасан дурын төхөөрөмжөөр Mozaik системийн бүх агуулгад хандах боломжтой байдаг.



Дэлгэрэнгүй мэдээллийг авахын тулд www.mozaweb.com хуудсаар зочлоорой.



Багш нар өөрийн ажлаа хөнгөвчилөхийн тулд tozaBook-д үүсгэсэн бүх агуулгыг үүлэн орчинд байршуулснаар эдгээр агуулгуудад tozaBook ажилладаг аль ч компьютерээс хандах боломжтой байдаг. Үүний үр дүнд багш нар зөөврийн компьютероо авч явах шаардлагагүй болно. Mozaik TEACHER лиценз нь ширээний компьютер болон интерактив самбарт мөн адил байдлаар ажилладаг.



Сурагчид хэрхэн гэрийн даалгавраа хийж, бие даан гэртээ хичээлээ давтаж болох вэ?

А Mozaik STUDENT лицензээр сурагчид дурын веб хөтчөөр mozaweb.com хуудсанд нэвтэрч, гэрийн даалгавраа хийх, багшийнхаа илгээсэн дасгалын дэвтрийг нээж үзэх боломжтой.

mozaik STUDENT лиценз

Хэрэглэгчийн лиценз бөгөөд нэг сурагч хэд хэдэн төхөөрөмж дээр tozaBook болон tozaWeb-ийн аль алиныг ашиглах боломжтой.

Сурагчид чөлөөт цагаараа Медиа санг сонирхон үзэж, өөрийн дуртай хичээлийнхээ мэдлэгийг гүнзгийрүүлэх боломжтой.

Сургалтын видео үзэн, хэрэгслүүд болон тоглоомоор үзсэн хичээлүүдээ бататгаж, өөрийн виртуал лабораторийг үүсгэж, mozaik3D үзэгдлүүдээс шинэ зүйлийг олж мэдэх боломжтой.



Сурагчид гэрээсээ tozaWeb бүртгэлдээ Windows, iOS болон Android үйлдлийн системтэй таблет дээрээс ч нэвтрэх боломжтой.

Худалдан авсан цахим сурах бичгүүдээ бүх платформуос нээж үзэх боломжтой.



тозаМар

интерактив самбарт зориулсан цахим газрын зураг

Интерактив самбар дээр ашиглаж болох цахим газрын зургууд нь газар зүй, түүхийн хичээлийн хэрэгслийн боломжийг өргөжүүлдэг. Төрөл бүрийн сэдэв бүхий газрын зургууд, тэдгээрийн элементүүдийг дангаар нь, эсвэл сонголт хийж ашиглах боломжтой нь хичээлд бэлтгэх, хичээл заах явцыг багагүй хөнгөвчилж өгдөг.



Дасгалууд

Та өөрийн тохируулсан газрын зураг дээр зургийн сангаас аж үйлдвэр, уул уурхай, газар тариалангийн гэх мэт пиктограмуудыг байрлуулж болно. Газрын зургийн зарим хэсгүүдийг шилжүүлж болдог. Мөн програм нь автоматаар дасгал үүсгэж, сурагчдын хариултуудыг хянах чадвартай.



Газрын зургийн дурын элементийг сонгохж, цуцлах, мөн хэрэгцээндээ тохируулснаар харагдах байдлыг томруулж хадгалах боломжтой байдаг.

Өөрийн үүсгэсэн газрын зураг, үзүүлэнгүүд

тозаМар-ын газрын зургуудыг ашиглан өөрийн газрын зургийг ч бас үүсгэх боломжтой байдаг. Газрын зураг дээр зураг, бичвэр, пиктограм болон тэмдэглэгээг байрлуулж, хадгалах ч боломжтой.



Урьдчилан тохируулга хийж хадгалсан харагдацууд

Урьдчилан тохируулсан харагдац түүхэн үйл явдлыг танилцуулахад дэмжлэг болдог. Хичээлийн материал дээр үндэслэн үүсгэсэн харагдацууд нь зөвхөн тухайн үеийн болон үйл явдлын онцлогуудыг харуулдаг.

mozAR



сурах бичиг дэхь өргөжүүлсэн бодит ертөнц

mozAR мобайл апп нь хэвлэмэл сурах бичгийн зураг, хичээлийн материалыг амилуулж, бодит ертөнцийг мобайл төхөөрөмжийн тусламжтайгаар тэлж өгдөг. Номын хуудсыг төхөөрөмжийн камераар уншуулахад агуулга нь дэлгэцэн дээр амилах болно.



Уг сэдэвт ямар интерактив агуулга тохирохоос хамааран 3D үзэгдэлд, анимейшн, хүүрнэл, хөгжим болон видеонууд гарч ирнэ.

MZAIK

Сурах бичгийн зурагууд амилна

3D үзэгдлээр түүхэн барилга байгууламжуудыг үзэж, урлагийн бүтээлүүдтэй танилцах боломжтой болдог. Молекулын бүтцийг өөрийн нүдээр харж, байгалийн нууцтай танилцан, өдөр тутмын хэрэглээний зүйлс хэрхэн ажилладаг талаар мэдэж аван, сэдэвт тохирох хүүрнэлт видеонуудыг үзэх боломжтой.



Загваруудыг чөлөөтэй эргүүлж, томруулж, янз бүрийн харагдах байдлаар (жишээлбэл огтлол) гаргах боломжтой.

Загварууд нь олон хэл дээр тайлбар, шошгонуудтай.



Зарим 3D үзэгдлээр сонирхолтой анимейшн, хүүрнэлүүдийг олон хэл дээр үзэх боломжтой байдаг.



- mozAR апп нь дизайн, тоглоомын шийдлүүдээрээ ухаалаг утас, таблетыг суралцах багаж хэрэгсэл болгон хувиргадаг.
- Үүнийг ашиглахад Mozaik сурах бичиг, камертай Android, эсвэл iOS мобайл төхөөрөмж, бас mozAR апп байхад л хангалттай.




euklides

хавтгайн геометр байгуулалтын программ

Геометрийн олон төрлийн бодлогыг манай Euklides геометр байгуулалтын программын тусламжтайгаар хялбархнаар, түргэн, оновчтойгоор бодох боломжтой.

Энэхүү программ нь зураг зурах үйл явцын үе шат бүрийг дараалалтайгаар гүйцэтгэх боломжтой бөгөөд дүрсүүд хэрхэн харилцан хамааралтайгаар үүсэж, нэг нэгэндээ тулгуурлан байгуулагдаж байгааг ажиглан судлах нөхцөлийг бүрдүүлдэг.

MOZAIK





Тодорхой бүтэц бүхий байгуулалт


Байгуулсан биетүүдийг ялган харахад дөхөмтэй болгохын тулд өөр өөр өнгөөр, шугамын хэлбэрээр харуулах боломжтой. Чухал биш туслах шугамуудыг ганц товшилтоор нууж болдог.

Энгийн болон нарийвчилсан байгуулалтууд

Энэхүү программ нь Евклидийн геометрийн зургаан үндсэн байгуулах алхмыг сургалтын гол зарчим болгон ашигладаг. Эдгээр алхмуудыг тодорхой дарааллын дагуу гүйцэтгэснээр үндсэн байгуулалт бий болдог. Үүний зэрэгцээ, суралцагчид байнга хэрэглэгддэг нэмэлт нарийвчилсан байгуулалтын алхмуудыг ч хэрэглэх боломжтой.



Зургаа бүрэн дуусгасны дараа ч тухайн дүрсийн хэсгүүдийг хөдөлгөх боломжтой бөгөөд үүгээр дамжуулан эхний нөхцөлүүдийн өөр өөр хувилбаруудыг гарган авч, тэдгээрийг харьцуулан шинжилж үзэх боломж бүрддэг.



Хөдөлгөөнт мөр үүсгэх

Уг программ нь нэг параметрийг байнга өөрчилвөл байгуулалтад ямар нөлөө үзүүлдэгийг маш тодорхойгоор харуулдаг. Жишээлбэл хоёр тойргийн радиусыг өөрчлөх үед уг тойргуудын огтлолцлын цэгийн хөдлөх мөрийг гаргаж болно. Эллипсийн муруйг гаргах үед ч яг адил зүйл болдог.


euler3D



огторгуйн геометр байгуулалтын програм

euler3D огторгуйн геометр байгуулалтын програм нь төрөл бүрийн огторгуйн биетүүд болон гадаргууг дүрслэн үзүүлэхийн зэрэгцээ өндөр түвшний математик нарийвчлалтайгаар эдгээрийг өөрчлөн засварлах боломжийг ч бас олгодог (дүрс өөрөө өөртэйгөө огтлолцсон эсэхийг шалгах, хавтгайн хугарлыг шинжлэх, конкав олон өнцөгтийг гурвалжингуудад хуваах).

MZAIK




Огторгуйн координатын систем

Дүрсийг орой, ирмэг болон талуудыг нь өгч тодорхойлж болдог. Координатын утгуудыг өгөхдөө тоон утгаас гадна үсгээр тэмдэглэсэн тогтмолуудыг ч бас хэрэглэх боломжтой.


Хэрэгцээндээ нийцүүлсэн байгуулалт

Дүрсийг шинжлэх явцдаа байгуулалтын явцыг хөнгөвчилөхийн тулд орой, ирмэгүүд болон талуудад нь тусгай нэвт харагдах давхарга үүсгэж, дуртай үедээ харагдуулж, эсвэл нуух боломжтой байдаг. Программ нь биетүүдийг дүрслэхдээ перспектив болон аксонометрийн проекцээр дүрсэлдэг. Бодитоор харагдуулахын тулд хоёр ширхэг гэрлийн эх үүсвэрийг ашигладаг.




Ашиглалт

Программаар эргэлтийн тэгш хэмтэй конус, бөмбөрцөг зэрэг биетүүдийг бас дүрсэлж болдог. Анимейшний тусламжтайгаар нарийн төвөгтэй огторгуйн харьцаа хамаарлуудыг (жишээлбэл. тетраэдрийн эзэлхүүний гаргалгаа) ч ойлгоход дөхөмтэй болно.



Уг программ нь математикийн бусад программ (Maple, Mathematica)-тэй холбогдох чадвартай. Байгуулалт бэлэн болсон биетүүдийг хэд хэдэн форматаар экспортлож болох ба зарим нэг төрлийн файлаас өгөгдлийг унших ч боломжтой байдаг.



mozaLand

онлайн сургалтын тэмцээн ба тоглоом

mozaLand онлайн сургалтын тоглоомын тусламжтайгаар сурагчид мэдлэгт суурилсан виртуал ертөнцийн иргэний хувьд математик, эх хэл болон байгалийн шинжлэх ухааны хичээлүүдээр олж авсан мэдлэгээ тоглоом хэлбэрээр гүнзгийрүүлэх боломжтой.



Хамгийн алдартай стратеги тоглоомуудын элементүүд дээр суурилдаг.

MZAIK



Хэрэглэхэд хялбар

Бүх функцэд энгийн хэрэглэгчийн интерфэйс болон газрын зураг дээр зүг чигээ олох замаар хандах боломжтой. Бид программын хэрэглээг аль болох хялбархан болгох талаар онцгой анхаарал хандуулсан тул бүх насныхан хялбархнаар, бие даан ашиглах боломжтой.

Зөвхөн тэмцээн биш


Сургуулийн уламжлалт тэмцээнүүдээс гадна ганцаарчилсан уралдаан, бүс нутаг, сургууль, анги хамт олны хооронд зохион байгуулагддаг багийн тэмцээнүүд ч онцгой ач холбогдолтой байдаг. Ийм төрлийн тэмцээнүүдэд сурагчид зөвхөн өөрийн биш, хамт олныхоо нэр төр, амжилтын төлөө мэдлэг, ур чадвараа дайчлан оролцдог.



Урам зориг өгөх

Хичээлийг тоглонгоо суралцдаг байсан бол ямар сайхан байх вэ? Тоглоом тоглох үеийн эрч хүчийг суралцахад ашигладаг бол ямар вэ? mozaLand онлайн танин мэдэхүйн тоглоом нь тоглоом тоглох хөөр баярыг шинийг сурах эрмэлзэлтэй хослуулан тоглогч бүрийг илүү их үр дүнд хүрэх урам зориг өгдөг.





MOSAIC




Хэвлэмэл нийтлэлүүд

- сурах бичиг,
дасгал ажлын
дэвтрүүд
- газар зүйн болон
түүхийн атласууд
- бодлогын цуглуулгууд
- мэдлэгийн түвшин
сорих товхимолууд



Хүрээлэн буй орчны нууц

"Хүрээлэн буй орчны нууц" цуврал нь "Өсвөр насныханд зориулсан шинжлэх ухаан" цувралын эхлэл болж, ахлах ангийн байгалийн ухааны хичээлүүдийн суурь мэдлэгийг бий болгоход чиглэдэг. Уг цуврал нь шинжлэх ухааны үндсэн ойлголтыг орчин үеийн баталгаатай, мэргэжлийн арга зүйгээр дамжуулан өгдөг.



Европын Шилдэг Сурах бичиг шагнал- 2009



Эдгээр номууд нь асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлдэг. Энд багтсан дасгалуудын тусламжтайгаар сурагчид байгаль орчны талаар мэдлэгтэй болж, дэлхийд болон найз нөхдийн хүрээлэлд нээлттэй хүн болон төлөвшидэг.

Unsere gefiederten Freunde

In den Stellungen finden die Wildvögel ausgezeichnete Nistplätze und genügend Nahrung. Einige sind nur im Winter, andere vom Frühling bis zum Sommer unsere Gäste, aber viele von ihnen leisten uns das ganze Jahr über Gesellschaft.

- Erinnere dich! Was sind die gemeinsamen Merkmale der Vögel?

DIE STADTTAUBEN

Die gemütlich auf den Straßen der Städte watschelnden, unterschiedlich gefärbten, verwilderten Hausstauben nennen wir Stadttauben. Sie erscheinen oft in imposanten Mengen auf den Plätzen der Städte.

- Schreibe die Namen der Körperteile auf die Linien! Was ist typisch für das Äußere der Stadttauben?

- Achte oben auf die ✓ Zeichen und zähle die mit der guten Flugfähigkeit der Tauben zusammenhängenden Merkmale auf!
- Wie heißen die markierten Teile des Kopfes und des Fußes? Wie bewegt sich die Taube? Wie gelangt sie an ihre Nahrung? Antworte mit Hilfe des folgenden Textes!

Die Stadttaupe bewegt sich in der Luft und auf dem Boden sehr geschickt. Beim Gehen berühren ihre vier Zehen den Boden. An den Enden der Zehen befinden sich starke Krallen. Die Taube ernährt sich hauptsächlich von Körnern. Das Ende ihres Schnabels ist hart, so kann sie die Körner leicht aufpicken.

Erforsche!
Zieh die unteren Äste der Taubenfeder vorsichtig auseinander! Sieh dir ihre Struktur unter der Lupe an! Welche Funktion haben die Federn?

DIE KOHLMEISE

Dank ihrer typischen Farbe und ihres typischen Gesanges gehört sie zu den beliebtesten Bewohnern von Garten und Park. Unermüdet stöbert sie zwischen Zweigen und durchsucht jeden Winkel nach Futter.

- Woran erkennst du die Kohlmeise? Male das Bild aus!

DIE AMSEL

Häufig vorkommender Vogel in jeder Siedlung. Sie ist am häufigsten auf dem Boden anzutreffen. Über ihren abwechslungsreichen Gesang, der das Ende der kalten Monate verkündet, freut sich jeder Mensch.

Sie sucht auf Bäumen und in Strüchern nach Futter. Mit ihren dünnen Füßen und ihren großen, krummen Krallen bewegt sie sich geschickt und klettert sich akrobatisch an den Ästen fest. Mit ihrem kurzen, spitzen Schnabel schnappt sie sich viele schädliche Insekten und Raupen. Im Herbst und im Winter ernährt sie sich von Körnern. Ihr Nest baut sie in einer Baumhöhle.

- Beschreibe das Äußere des Amselmännchens! Worin unterscheidet sich das Weibchen von ihm?

Dank ihrer langen Beine und ihrer dunklen Federn kann sich die Amsel lange Zeit auf dem Boden aufhalten. Hier sucht sie mit ihrem langen, spitzen Schnabel nach Insekten, Würmern und Schnecken. Im Herbst und im Winter gehören auch Obst und Beeren zu ihrer Nahrung. Sie nistet vorwiegend in Sträuchern.

- Worin unterscheidet sich die Schnabelform des Habichts von denen der bisher kennengelernten Vögel?

Living and inanimate environment

1. The school premises, residential houses and objects were created by people. List the objects shown on the picture. Count the number of plants, animals and objects on the picture. Colour as many circles as the number of objects you've found.



2. Tell what similarities and differences are there between the members of the pairs on the pictures. Mark the inanimate objects with a star.




Let's play! Collect pictures of various living things. Form teams. Group pictures according to criteria of your own choice. Also look for new grouping criteria. At the end of the game, one pupil from each team explains the grouping criteria.

3. You must have taken part in excursion in the forest before. What did you see there? List the things which surround John in the forest.



5. Cross the odd one out in each group. Give reasons for your choice.



Useful to memorize! The environment around us can be natural or artificial. The natural environment is made up of living and inanimate things. Living things exhibit phenomena associated with life, which inanimate objects don't show.

Уг сурах бичгүүдийн гол зорилгын нэг нь сурагчдад суралцах зөв дадал хэвшил бий болгох явдал юм. Энэ зорилгод хүрэхэд номонд ашигласан сурагчдын насны онцлогт тохирсон өнгө, дүрслэлийн байнгын хэрэглээ нь тусладаг.

菌类世界

在森林中，蘑菇通常生长在在下层草质层的生物体，它们有各种不同的形状、大小和颜色。




蘑菇喜欢生长在阴暗潮湿的地方。与植物不同，它们是不能为自己制造营养物质的异养生物。蘑菇需要从周围的环境中吸取营养物质，既不是动物，也不是植物，而是一种独立存在的生物种类。

菌类的生长 真菌的种类有很多，有以消耗植物为生的菌类，也有一些寄生在动物身上的菌类。菌类可以分解大量的物质，它们帮助清理生物世界遗留的“垃圾”，形成简单的物质，从而提高土壤的肥力。

